



**ХЭНТИЙ АЙМГИЙН
НОРОВЛИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 07 өдөр

Дугаар 6/01

Жаргалант


Б.Түмэннастыг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Цагдаагийн албаны тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1, 63.8 дахь хэсэг, Хэнтий аймгийн Иргэдийн Төлөөлөгчийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 03-ний өдрийн хоёрдугаар хуралдааны 06 дугаар тогтоол, Норовлин сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ нь:**

1.Нутаг дэвсгэрийн хэмжээнд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор тус сумын Олон нийтийн цагдаагаар Баярмаагийн Түмэннастыг 2025 оны 01 дүгээр сарын 07-ний өдрөөс томилсугай.

2.Б.Түмэннастын сарын урамшуулалыг 1,200,000 (нэг сая хоёр зуун мянга) төгрөгөөр тооцож сар бүр сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас олгохыг нягтлан бодогч (Л.Энхдорж)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ө.ДАВААЖАРГАЛ